

**ÚLTIMA**

# Гарчиг:

|                                                                             |    |
|-----------------------------------------------------------------------------|----|
| 1. Executive Summary . . . . .                                              | 3  |
| 2. Зах зээлийн задлан шинжлэл . . . . .                                     | 3  |
| 2.1. Зах зээлийн одоогийн төлөв байдал . . . . .                            | 3  |
| 2.2. Кибер гэмт хэрэгтнүүдийн идэвхийн бууралт . . . . .                    | 4  |
| 2.3. Зах зээлийн хөгжлийн чиг хандлагууд . . . . .                          | 5  |
| 2.4. Ойрын 5 жилийн таамаглал . . . . .                                     | 6  |
| 3. Эрхэм зорилго . . . . .                                                  | 7  |
| 3.1. Криптовалютын ямар асуудлыг Ultima шийддэг вэ? . . . . .               | 8  |
| 4. Ultima-гийн түүх . . . . .                                               | 8  |
| 5. Ultima токены үнэ цэнийн өсөлтийн стратеги . . . . .                     | 9  |
| 6. Ultima нийгэмлэг . . . . .                                               | 10 |
| 7. Ultima экосистем . . . . .                                               | 11 |
| 7.1. Экосистемийн ажиллаж буй бүтээгдэхүүн болон технологийн тойм . . . . . | 12 |
| 7.2. Боловсруулж буй бүтээгдэхүүнүүд . . . . .                              | 17 |
| 8. Road map . . . . .                                                       | 18 |
| 9. Зах зээлийн сорилтууд . . . . .                                          | 21 |
| 10. Хариуцлагын тухай мэдэгдэл . . . . .                                    | 21 |

# 1. Executive Summary

Энэ баримт бичигт Ultima баг 2022 оны III улирал — 2023 оны I улирлын криптовалютын зах зээлийн төлөв байдалд задлан шинжлэл хийж, ULTIMA-гийн зах зээлд эзлэх үүргийн талаар тайлбарласан болно. Энэ баримт бичгээс та төслийн эрхэм зорилго, түүх, үндсэн технологи болон бүтээгдэхүүний тухай мэдээллийг олох болно. Та манай багийн нэг гаруй жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлж буй ULTIMA-гийн үнийг дэмжих стратеги болон төслийн ойрын ирээдүйн төлөвлөгөөний талаар мэдэж авах болно.

## 2. Зах зээлийн задлан шинжлэл

### 2.1. Зах зээлийн одоогийн төлөв байдал

Санхүүгийн зах зээл дээр мөчлөг солигдож байдагт бид дассан билээ: баавгайн зах зээлийн оронд бухын зах зээл ирдэг, гэхдээ уламжлалт зах зээлийн хувьд таамаглал дэвшүүлж, төлөвлөгөө гаргахад амархан байдаг бол криптовалютын зах зээлд таамаг гаргах нь ихэвчлэн урам хугарахад хүргэж, бусдын нүдэнд хоосон толгой болж харагдах болдог.

Энэ он крипто зах зээлийн сэргэлтийн он байлаа. Оны эхэнд Bitcoin-ы үнэ 20 мянган \$ байсан бол хаврын эхэнд 60 мянган \$ хүртэл өсөж, энэ түвшнээс буурахгүй байсаар байна. Ethereum мөн адил гайхалтай өсөлтийг харуулсан бөгөөд түүний одоогийн ханш 2300 \$-ыг давсан байна.

Энэ өсөлтийн шалтгаануудыг дурдвал институционал хөрөнгө оруулагчдын сонирхож буй өсөлт, дөрөвдүгээр сард спот Bitcoin ба Ethereum ETF Америкийн зах зээлд гарсан явдал, мөн кибер гэмт хэрэгтнүүдийн криптовалютын орон зай дахь идэвхийн бууралт байна.

Үүний зэрэгцээ өсөлтийг хязгаарлах шалтгаанууд байгаа бөгөөд тэд сүүлийн жилүүдэд өөрчлөгдөхгүй хэвээр үлдсээр байна: энэ бол зохицуулах байгууллагуудаас крипто компаниудад үзүүлэх дарамтын өсөлт, тэр дундаа тогтмол зохион байгуулагддаг шинэ [хянан шалгах](#) ажиллагаанууд ба төрөл бүрийн хоригийн горимыг тойрохын тулд криптовалют ашиглах боломжийг хязгаарлах оролдлогууд байна. Түүнчлэн, эдийн засгийн хямралын давлагааны нөхцөлд [Герман](#) зэрэг томоохон хэд хэдэн улс төрийн зардлын хомсдолоо нөхөхийн тулд криптовалютын нөөцөө зарж эхэлсэн. Мэдээжийн хэрэг энэ нь үнэ буурахад хүргэнэ. Гэхдээ одоохондоо сөрөг хүчин зүйлс эерэг хандлагыг дийлээгүй байна.

Өсөлтийн үндсэн түлхэц нь спот ETF байсан. BTC-ийн ханшийн өсөлтийн шинэ давлагааны эхлэл 2024 оны нэгдүгээр сард SEC Bitcoin ETF-ийн хүлээн зөвшөөрч, [арилжаа эхэлсэнтэй](#) яг давхацсан. [Долдугаар сард](#) Америкийн зах зээлд гарсан спот Ethereum ETF мөн эфир болон биткоины ханшийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн.


Өсөлтийн шалтгаанаас үл хамааран Bitcoin болон Ethereum нь эргэлзэгчид тэднийг хэт эрт “оршуулсан” гэдгийг дахин нэг удаа харуулж байна. Зах зээлийн одоогийн нөхцөл байдал нь богино болон урт хугацааны хөрөнгө оруулалтын хувьд боломжуудыг нээж байна. Гэхдээ цаашдын өсөлтийн тулд “томоохон” хөрөнгүүд эсэргүүцлийн олон хязгаарыг даван туулах шаардлагатай болно гэдгийг тооцох хэрэгтэй.

Альткоин дурын портфайлын зохих хэсэг байж болох ч өмнөх шигээ тэдэнтэй болгоомжтой харьцах хэрэгтэй, ялангуяа эрсдэлтэй хөрөнгийн хувьд.

## 2.2. Кибер гэмт хэрэгтнүүдийн идэвхийн бууралт


Блокчейн салбартай холбоогүй хүмүүсийн дунд криптовалюта нь гэмт хэрэг үйлдэх, мөнгө угаах болон бусад хууль бус үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашигладаг хөрөнгө гэсэн нэр хүндтэй байдаг. Энэ байдал аажмаар сайжирч байгаа бөгөөд сүүлийн үед энэ салбарт гайхалтай ахиц дэвшил гарч байна.

Тухайлбал, Chainalysis-ийн 2024 оны крипто гэмт хэргийн тухай тайланд дурдсанаар 2023 онд хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг нь анзаарагдсан хаягтай холбоотой гүйлгээний хэмжээ огцом буурч, бараг 40 тэрбум доллараас 24,2 тэрбум доллар хүртэл багассан байна.



Үүний зэрэгцээ ийм төрлийн тайланд ашигладаг тооцооллын онцгой аргачлалын талаар санах нь бас чухал. “Хууль бус” гүйлгээний дийлэнх хувь нь (62.5%) нь АНУ эсвэл ЕХ-ны хориг тавигдсан компани эсвэл харьяалалтай холбоотой шалтгааны улмаас ийм статустай болсон. Өөрөөр хэлбэл ОХУ-ын нутаг дэвсгэрт хийсэн бүх гүйлгээг тус тайланд “хууль бус” гэж тооцсон гэсэн үг.

Түүнчлэн хэтэвч, бирж, кроссчейн гүүр болон бусад үйлчилгээг хакердсаны улмаас хулгайлагдсан хөрөнгийн хэмжээ буурсан. Кripto хулгайн дээд амжилт тогтоогдсон 2022 онд хулгайлагдсан хөрөнгийн хэмжээ 3,7 тэрбум ам.долларыг давсан бол 2023 онд тус үзүүлэлт хоёр дахин буурч, 1,7 тэрбум доллар болсон. Мөн хакерын халдлагын тоо эрс биш ч гэсэн тодорхой хэмжээгээр багассан.



Гэсэн хэдий ч энэ нь крипто ертөнцөд диваажин бий болсон, бид одоо хамгаалалтаа суллаж болно гэсэн үг биш. Эсрэгээр нь шинэ, илүү боловсронгуй халдлагын аргууд гарч ирэх төлөвтэй байна. Тиймээс дижитал хөрөнгөтэй харьцахдаа аюулгүй байдлын дүрмийг баримтлах нь чухал хэвээр байна.

## 2.3. Зах зээлийн хөгжлийн чиг хандлагууд


Институционал хөрөнгө оруулагчдын криптовалютыг сонирхох сонирхол өсөж буй чиг хандлага хадгалагдаж байна. Хэрэв өмнө нь криптовалютыг ихэвчлэн хөрөнгө оруулалтын сангууд, томоохон технологийн корпорациуд эсвэл Элон Маск зэрэг алдартай хүмүүсийн удирддаг компаниуд худалдаж авдаг байсан бол 2024 онд гүнзгий консерватив байр суурьтай тоглогчид дижитал валютыг авч эхэлсэн.

Жишээлбэл, оны хоёрдугаар улиралд [Goldman Sachs крипто ETF-д](#) бараг хагас сая тэрбумын хөрөнгө оруулалт хийсэн (\$438M). Тиймээс криптовалютын хөрөнгө оруулалт нийт дэлхийн санхүүгийн тогтолцооны үнэхээр чухал чиг хандлага болсон.

4-р сарын 19-нд болсон халвинг өмнөх ижил төстэй үйл явдлуудаас ялгаатай нь биткоины үнийг өсгөх томоохон түлхэц болж чадаагүй нь сонирхолтой.

Тухайлбал, Outlier Ventures 2024 оны халвинг нь Bitcoin-ы үнэд үзүүлсэн нөлөөний хувьд криптовалютын оршин тогтнож буй түүхэн дэх хамгийн муу халвинг байсан гэж [тайландаа](#) шууд бичжээ.

Exhibit 4: BTC price performance AFTER each halving across epochs



Source: Outlier Ventures

Түүгээр ч барахгүй энэ бол халвингаас хойш 200 хоногийн дараа Bitcoin халвингийн үеийнхээс доогуур (бага зэрэг ч гэсэн) үнээр арилжаалагдсан анхны тохиолдол юм.

Биткоины үнийг ETF-ийн галзуу эрэлт өсгөсөн хэдий ч энэ удаад халвинг нь өсөлтийн томоохон түлхэц болсонгүй нь тодорхой байна. Үүнтэй холбогдуулан шинжээчид халвингтай холбоотой алдарт “биткоины дөрвөн жилийн мөчлөг” тасарсан гэж ярьж байна. Энэ нь урт хугацааны таамаглалыг улам хүндрүүлдэг.

## 2.4. Ойрын 5 жилийн таамаглал

Криптовалютын зах зээлийн ойрын 5 жилийн хөдөлгөөнийг нарийвчлан таамаглах боломжгүй. Дижитал хөрөнгөд гаднын олон хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд ихэнх нь ямар ч үед өөрчлөгдөж болно. Гэхдээ зах зээлийн ерөнхий хандлага өөдрөг байгаа бөгөөд яагаад гэдэг нь ойлгомжтой байна.

Өмнөх оны “консерватив өөдрөг” таамаг ерөнхийдөө үнэн байлаа. Шинжээчдийн нийгэмлэгээс 2024 оны эцэст биткоины үнэ \$50 000 хавьцаа байна гэсэн үнэлгээ өгсөн. Харин одоо BTC-ийн ханш \$90 000-ийг давсан бөгөөд хоёрдугаар сарын дундаас хойш үнэ нь \$50K-аас буураагүй. Үүнтэй холбогдуулан 2025 онд ханш \$100 000-аас дээш тогтоно гэсэн таамаг тийм ч гэнэн харагдахгүй байна.

Гэхдээ криптовалютын динамикийн үндэс нь мөчлөг гэдгийг шинжээчид онцолж байна. Энэ талаараа дижитал хөрөнгийн зах зээл нь өсөлт бүрийг уналт, харин уналт бүрийг өсөлт дагадаг үнэт цаасны зах зээлтэй төстэй юм.

Криптовалют нь үнийн уналтыг нэг бус удаа даван гарч, өмнөх дээд цэгтээ үргэлж эргэн ирж, дараа нь шинэ дээд цэгийг тогтоодог байсан. Тийм учраас дижитал хөрөнгө нь хөрөнгө оруулагчдын хувьд, ялангуяа урт хугацааны хөрөнгө оруулалтын хувьд сонирхол татсан хэвээр байна. Гэхдээ ойрын ирээдүйд ноцтой бөгөөд урт хугацааны коррекц болохгүй гэж таамаглах нь гэнэн байх болно.

### 3. Эрхэм зорилго

Манай эрхэм зорилго бол дэлхий дээр хамгийн өргөн хэрэглэгддэг криптовалюта бөгөөд хүн бүрийн хувьд хүртээмжтэй экосистем болох юм. ULTIMA бол гипердефляцийн токен бөгөөд үүнийг хэрэглэгчдэд урамшуулал хэлбэрээр олгодог (ULTIMA авах механизмын тухай дэлгэрэнгүйг бид доор тайлбарлана).

Хэрэглэгч нь токенохоо цорын ганц эзэмшигч байна. Тэр чөлөөтэй токен хүлээн авах, зарцуулах, шилжүүлэх, хадгалах, өвлүүлэх, мөн бусад ажиллагааг хямд, хурдан бөгөөд аюулгүй хийх боломжтой.

Шинэ технологи хөгжүүлж, нэвтрүүлсний ачаар Ultima криптосистемд биткоин болон бусад зоосны концепцод байдаг алдаа дутагдлыг тооцож үзэн, засаж залруулсан юм. Үүний зэрэгцээ бид зах зээл дээрх бусад зоостой өрсөлддөггүй, харин өөрийн гэсэн хувийн зах зээлийг үүсгэж, одоо аль хэдийн тэргүүлэх байр суурийг эзлээд байна.

ULTIMA нь дэлхийд хамгийн их хэрэглэгддэг дижитал валют, крипто орон зайд хамгийн их хэрэглэгддэг экосистем болоход үнэхээр тэмүүлж байна. Ultima токеныг анхнаас нь өдөр тутмын хэрэглээний төлбөрийн хэрэгсэл болгон ашиглахад аль болох тохиромжтой байхаар бодож бүтээсэн. Зах зээлийн зарим оролцогч биткоиноор бараа, үйлчилгээний төлбөр хийх боломжийг санал болгодог ч уг валютыг төлбөр төлөх бодит арга биш, харин маркетингийн хэрэгсэл болгож голчлон ашигладаг. Биткоин ашиглан хийсэн нийт гүйлгээний 90 гаруй хувь нь зах зээлийн спекуляц байдаг.

Харин ULTIMA нь фиат валют оруулах шинэ цэг болохоор төлөвлөж байна. Гүйлгээ хийх хугацаа нь хурдан, тогтворгүй байдлын эрсдэл нь бага байх болно. Ultima бол дэлхийн дурын цэгээс зуучлагчгүй хийх шуурхай гүйлгээ, бодит цагийн горимд ажиллах хоногийн 24 цагийн үйл ажиллагаа, системийн аюулгүй байдал ба хамгаалалт, хараат бус байдал, нэрийн бүрэн нууцлал, ULTIMA-г фиат мөнгө болон бусад зоос болгох чөлөөт хөрвүүлэлт юм.

### 3.1. Криптовалютын ямар асуудлыг Ultima шийддэг вэ?

**Асуудал:** тогтворгүй ханш

**Шийдэл:** өсөлтийн стратегид ханшийг тогтворжуулах цогц арга хэмжээ багтдаг: токеныг тогтмол шатаах, дефляцийн механизм, нийгэмлэгийн байнгын өсөлт болон бусад.

**Асуудал:** техникийн мэдлэггүй хэрэглэгчдэд ихэнх криптовалютыг ашиглахад хэцүү байдаг

**Шийдэл:** Ultima-гийн хэрэглэгчдийн талаас илүү хувь нь криптовалютын зах зээлд шинээр орсон хүмүүс байдаг. Ultima багийн нэг зорилго бол бүтээгдэхүүн ба аппликэйшнийг хамгийн энгийн бөгөөд ажиллуулахад хялбар болгох юм. Ашиглахад хялбар интерфэйсээс гадна хэрэглэгчид бүтээгдэхүүнтэй ажиллах хамгийн дэлгэрэнгүй зааврыг авна. Түүнээс гадна, Ultima-гийн тусламжийн баг амралтын өдөргүй ажиллаж, 8 хэлээр цаг тухайд нь туслалцаа үзүүлдэг.

## 4. Ultima-гийн түүх

Ultima-гийн түүх анх Швейцар улсад 2016 онд эхэлсэн. Тус төсөл нь крипто бүтээгдэхүүн, төлбөрийн систем дээр ажилласан арвин туршлагатай мэргэжлийн хөгжүүлэгчдийн багаас эхэлж байсан. Өнөөдрийн байдлаар Ultima 120 гаруй улсад ажиллаж байна.

Одоо байгаа криптовалютуудын асуудлыг шийдэж чадах блокчейн бүтээх санаа нь тэртээ 2016 онд бүтээгчдэд орж ирсэн. 2017 онд тус санаа нь анхны биеллээ олж авсан. Дараа нь 2018 онд дефляцийн coinbase гүйлгээнд суурилсан шинэчлэгдсэн блокчейн гарч ирсэн. Багийн хөгжлийн шинэ үе шат орчин үеийн блокчейний шилдгүүдийг агуулсан төсөл буюу Smart Blockchain-ий эхлэл байсан юм.

Smart Blockchain-ий үүсгэн байгуулагч Райнхардт Алекс анхны блокчейн шинээр бүтээгчдийн нэг болсон. Райнхардт Алекс бол блокчейн технологийн мэргэжилтэн, эдийн засагч, венчур хөрөнгө оруулагч, цуврал бизнес эрхлэгч юм.

Тэр гарааны бизнес болон венчур хөрөнгө оруулалтын салбарт 10 гаруй жил ажиллаж, инновацыг ойлгох болон үнэлэх гайхалтай туршлага хуримтлуулж юм. 1,5 жилийн хугацаанд тэр хэдэн арван сая долларын эргэлт бүхий хэд хэдэн бизнес босгож, өнөөдөр дэлхий даяар 2'800'000 гаруй хүнийг нэгтгэсэн олон улсын нийгэмлэгийг байгуулсан юм.



The Entrepreneur хэмээх томоохон хэвлэл Алексейг крипто салбарын хамгийн нөлөө бүхий 10 хүний жагсаалтад [оруулсан](#) аж. The Entrepreneur бол 1979 оноос эхлэн гарч буй дэлхийн хамгийн алдартай, нөлөө бүхий бизнесийн хэвлэлийн нэг юм. The Entrepreneur нь маркетинг, бизнес, бизнес эрхлэлт, борлуулалт, санхүүгийн талаар нийтлэл гаргадаг. Сар бүр тус хэвлэлийн сайтаар бараг 15 сая хүн зочилдог бөгөөд энэ нь Forbes, Inc., Bloomberg гэх мэт хэвлэл мэдээллийн салбарын аваргуудтай харьцуулахуйц тоо юм. Харин Arabian Business сэтгүүл Райнхардт Алексейг Дубайн хамгийн нөлөө бүхий 100 хүний жагсаалтад оруулсан юм.

Ultima-гийн хөгжлийн шинэ үе шат нь хэрэглэгчдэд блокчейнтэй шууд харилцаж, сплит токен эзэмшсэнийхээ төлөө ULTIMA-аар урамшуулал авах боломжийг олгодог өвөрмөц шийдэл болох DeFi-U бүтээгдэхүүн болсон юм. Бүтээгдэхүүний ажиллагааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг тус баримт бичгийн “Ultima экосистем” хэсэгт тайлбарлана.

## 5. Ultima токены үнэ цэнийн өсөлтийн стратеги

Төслийг анх бий болгох санааны үе шатанд Ultima баг токены өсөлтийн стратегийг бодож боловсруулсан. Тус стратеги нь баавгайн зах зээлийн үед ч гэсэн хөрвөх чадвар ба ханшийн тогтвортой байдлыг хадгалах боломжийг олгодог аж. Ultima баг дефляцийн стратегийг сонгосон. Уг стратеги нь дараах чиглэлүүдийг багтаадаг:

### 1. Хязгаарлагдмал нийлүүлэлт

Зах зээл дээрх токены нийт хэмжээ: 100 000

### 2. Хөрвөх чадварын төлөөллийн сан бий болгох

Ultima-ийн үндсэн технологи буюу сплитинг нь хөрвөх чадварын сангууд дээр суурилж ажилладаг — эдгээр нь гишүүдийн дунд урамшуулал хуваарилдаг, блокчейн дээр ажилладаг төвлөрсөн бус системүүд юм.

Өдөр бүр сплит токены эзэмшигчдийн дунд хэд хэдэн хөрвөх чадварын сангаас ULTIMA токеныг хуваарилдаг. Экосистемд хэд хэдэн хөрвөх чадварын сан байдаг бөгөөд тэдгээрийн талаар бид “Ultima экосистем” хэсэгт дэлгэрэнгүй тайлбарлана. Хуваарилалт нь сплитийн тоогоор пропорциональ байдлаар явагддаг — эзэмшигч хэдий чинээ олон сплит токентой байна, төдий чинээ их урамшуулал тэр ULTIMA-аар хүртэнэ.

### 3. Халвинг

Блокчейнд халвингийн дүрэм хэрэгждэг бөгөөд үүний дагуу 10 000 000 блок тутамд өдөр бүр хуваарилж буй токены тоо 2 дахин багасдаг.

### 4. Томоохон дэд бүтэц

Ихэвчлэн спекуляцийн зорилгоор бүтээгдсэн зах зээлийн ихэнх криптовалютаас ялгаатай нь Ultima token бол орчин үеийн бүтээгдэхүүнүүд агуулсан криптовалютын томоохон дэд бүтцийн нэг хэсэг бөгөөд зарим бүтээгдэхүүн нь одоогийн байдлаар зах зээл дээр ижил төстэй бүтээгдэхүүнгүй байна. Төслийн дэд бүтцийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэ баримт бичгийн 7-р заалтад тайлбарлана.

## 6. Ultima нийгэмлэг

Ultima нийгэмлэг бол хөгжлийн гипердефляцийн стратегийн гол бүрэлдэхүүн бөгөөд төслийн өрсөлдөх чадварын томоохон давуу тал юм. Худалдаанд гаргасан мөчөөс эхлэн манай баг нийгэмлэгийн хөгжлийг ажлын гол зорилтуудын нэг болгож зарласан.

Одоогийн байдлаар экосистемийн бүтээгдэхүүний хэрэглэгчдийн тоо 3 000 000-г давсан бөгөөд хэрэглэгч тус бүр нь крипто сонирхогчдын глобал нийгэмлэгийн гишүүн болж, экосистемийг дэлхийн крипто зах зээл дээр сурталчлах хүчирхэг суваг бүрдүүлдэг. Үүний хажуугаар нийгэмлэг тогтмол тэлж, нийгэмлэгийн өсөлттэй пропорционалаар зах зээл дээр боломжтой ULTIMA токены тоо буурч буй нь ULTIMA токены үнэ цэнийг бэхжүүлдэг юм.

Ultima нийгэмлэгийн гишүүд сплитингийн ачаар шагнал хуваарилалтад оролцон, ханшийн өсөлтөөс орлого олж Ultima-гийн дэд бүтцийн төслүүдийг ашиглан (маркетплейс, краудфандинг платформ гэх мэт) арилжаа хийдэг. Бүх үйл ажиллагаанд ULTIMA хэрэгтэй байдаг тул бараг гурван сая хүний идэвхтэй байдал болон токены хязгаарлагдмал нийлүүлэлт нь үндсэн токены өсөлтөд шууд нөлөөлдөг. Эдгээр хүчин зүйлийн нэгдэл нь Ultima экосистемийн үндсэн токенод эергээр нөлөөлдөг.

Өнөөдрийн байдлаар Ultima крипто нийгэмлэг нь зах зээл дээрх томоохон бөгөөд олон соёл багтсан нийгэмлэгүүдийн нэг болоод байна. Латин Америкаас Герман хүртэл уулзалт ба сургалтын арга хэмжээ зохион байгуулагддаг нь хүчирхэг бөгөөд үнэнч нийгэмлэгийг өдөр ирэх тусам тэлэх боломжийг олгодог! Ultima багийн нийгэмлэгээ хөгжүүлэх ийм арга барил бол криптовалютын ертөнцөд ховор тохиолддог бөгөөд төслийн өсөлтийн гол хөдөлгөгч хүчний нэг юм.

Түүнчлэн Ultima-ийн баг блокчейний хэрэглээг өргөжүүлэх, инновацийн дэд бүтцийг нэгтгэх зорилгоор стратеги болон технологийн түншлэлийг идэвхтэй хөгжүүлж байна. Бид Paris Blockchain Week, Хонг Конг дахь Web3 арга хэмжээ зэрэг салбарын арга хэмжээнд тогтмол оролцож, төсөл, гарааны бизнес эрхлэгчидтэй түншлэл болон хөрөнгө оруулалтын талаар хэлэлцээ хийдэг. Одоогоор бид дэд бүтцийг манай L1 блокчейнд нэгтгэх талаар гурван төсөлтэй ярилцаж байна.

## 7. Ultima экосистем

Ultima нь зүгээр ч нэг нийгэмлэг биш, харин бүтээгдэхүүний томоохон экосистем юм. Криптовалютын эриний эхлэл үед криптовалютын дэд бүтцэд тавих шаардлагын жагсаалт тийм ч урт биш байв: криптовалюта олборлох, хадгалах, худалдаж авах, худалдаалах боломж байхад л хангалттай байсан буюу энэ нь үнэндээ спекуляц арилжаанаас ашиг олдог хэрэгсэл гэсэн нэр хүндийг криптовалютад авчирсан юм. Галзуу крипто зах зээлийн цаг үе түүхнээ бүдгэрэн үлдэж буй өнөө үед зөвхөн криптовалюта олборлох, хадгалах, худалдаалахаас гадна худалдан авалтын төлбөр хийх, краудфандинг төслийг дэмжих, хувийн бизнесээ босгоход ашиглах боломжийг олгодог дэд бүтцийн бүтээгдэхүүний дотор ажилладаг төслүүд хамгийн их амжилтыг олж байна.

Ингэж тогтвортой байдал ба цаашдын хөгжлийн өргөн боломж бололцооны хослолыг агуулах давуу талтай нарийн төвөгтэй бөгөөд бие даасан зохион байгуулалттай орчин болох криптовалютын экосистем үүсдэг. Жишээлбэл, ердийн крипто биржийн хүрээнээс хэдийн хэтэрсэн Ethereum эсвэл Binance Smart Chain экосистемийг өнөөдөр ийм экосистемд тооцож болно.

Ultima ч гэсэн цогц бөгөөд олон түвшинтэй дэд бүтцээр урт хугацааны тогтвортой хөгжлийг хангадаг ийм экосистемийн тоонд багтана. Криптовалютын хэрэглэгчдийн тоог тасралтгүй өсгөж, бодит амьдрал дээр өдөр тутмын хэрэгцээндээ токен ашиглах боломжоор тэднийг хангахын тулд Ultima баг зүгээр л нэг бүрэн төвлөрсөн бус хуваарилалттай хувийн блокчейнээс гадна өндөр технологийн бүтээгдэхүүний бүрэн цогцолборыг үүсгэсэн юм.

Өнөөдөр Ultima экосистемд хэд хэдэн хөрвөх чадварын сантай DeFi-U өвөрмөц бүтээгдэхүүн, Ultima Trading платформ, SMART Wallet хэтэвч, Ultima Store маркетплейс, түүнчлэн виртуал болон биет крипто карт багтаж байна.

Краудфандинг платформ, аяллын платформ, криптобирж болон бусад олон олон зүйл хөгжүүлэлтийн шатанд байна.

## 7.1. Экосистемийн ажиллаж буй бүтээгдэхүүн болон технологийн тойм

### 7.1.1. Сплитинг

Сплитинг бол DeFi-U бүтээгдэхүүн суурилж ажилладаг Ultima экосистемийн түлхүүр технологи. Сплитинг нь хөрвөх чадварын санд суурилдаг – энэ бол хаалттай бөгөөд өөрийгөө дэмждэг төвлөрсөн бус систем юм. Ерөнхийдөө хөрвөх чадварын сан гэдэг нь криптовалютын том хэтэвч юм. Түүнд хэдэн арван жилээр царцаасан криптовалютууд байрладаг. Энэ хэтэвч нь төвлөрсөн бус буюу эзэнгүй юм. Энэ нь зөвхөн блокчейнд хамаарагддаг бөгөөд зөвхөн блокчейн дансанд нь хадгалагдаж буй токеныг удирдан зарцуулах боломжтой. Одоогийн байдлаар экосистемд хэд хэдэн сан ажиллаж байгаа бөгөөд сан тус бүр нь сплит токен царцаасан хэрэглэгчдэд урамшуулал хуваарилдаг.

Блокчейн нь ухаалаг гэрээний нарийн дүрмийн дагуу урамшуулал олгодог. Ухаалаг гэрээнд алгоритмийн дагуу зах зээл дээр хөрвөх чадварыг нэмэгдүүлсэн хэрэглэгчийг шагнах дүрэм бий. Урамшуулал эзэмших эрхийг сплит гэх тусгай хэсгээр тодорхойлно.

Сплит гэдэг нь хэрэглэгчийн шагнал хүртэх эрхийг тодорхойлох онцгой үүрэгтэй токены төрөл юм. Өдөр бүр санд тодорхой хэмжээний криптовалют хуваарилдаг бөгөөд энэ хэмжээг оролцогчдын царцаасан сплит токены нийт тоонд хуваадаг. Хэрэглэгч хэдий чинээ олон царцаасан сплиттэй байна, төдий чинээ шагнал нь өндөр байна.

Сан нь сплит тус бүрд сангийн дүрмийн дагуу өдөр тутам урамшуулал тооцоолдог. Хуваарилагдах урамшууллын хэмжээ нь хэтэвчинд сплит царцаасан хугацаа ба халвингийн хугацаанаас хамаарна.

Одоогийн байдлаар сангуудад тэдний төрлөөс хамааран өдөр бүр 5 хүртэл коиныг оролцогчдын дунд тэдэнд байгаа сплитийн хэмжээний дагуу хуваарилж байна. Тус дүнг оролцогчдын нийт сплит токены тоонд хуваадаг. Гарсан дүнг тухайн хэрэглэгчид буй сплит токены тоогоор үржүүлдэг. Дараагийн халвингийн дараа энэ хэмжээ нь хоёр дахин буурч, үргэлжлүүлэн буурсаар байх болно. Энэ нь урамшууллын хэмжээ мөн буурна гэсэн үг юм.

### 7.1.2. Ultima Trading

[Ultima Trading](#) гэдэг нь BingX ба MEXC зэрэг тэргүүлэх криптовалютын биржүүд дээр ажилладаг крипто трейдингийн автоматжуулсан платформ юм. Тус платформ нь хэрэглэгчдэд 24 цагийн турш ажиллаж, шалгарсан алгоритмын стратегиудыг ашиглан USDT-ээр ашиг үүсгэдэг арилжааны ботуудыг ашиглах боломжийг олгодог.

Ботуудыг тусгай багцуудаар дамжуулан идэвхжүүлнэ. Багц тус бүр нь хэрэглэгчид тодорхой тооны бот болон арилжааны хүчин чадлын түвшинд нэвтрэх боломжийг нээнэ. Үүний зэрэгцээ ашиг олох баталгаа байхгүй, гэхдээ лицензийг ашиглах нь арилжааны бүтээмжийг мэдэгдэхүйц өсгөх боломжийг олгодог.

Өнөөдрийн байдлаар тус платформд 120 000 гаруй бүртгэлтэй хэрэглэгч нэгдсэн байгаа нь эрэлтийн өндөр түвшинг харуулж, бүтээгдэхүүний тогтвортой хөгжлийг баталгаажуулж байна.

Ultima Trading нь мэргэжлийн трейдерүүд болон зах зээлийн талаар гүнзгий ойлголт эсвэл програмчлалын ур чадвар шаарддаггүй шинэ хэрэглэгчдэд аль алинд нь зориулагдсан. Бүх үйл явцыг дээд зэргээр хялбаршуулсан: аккаунтаа биржтэй холбож, лицензийг идэвхжүүлж, арилжааны хосыг сонгоход хангалттай (жишээлбэл, ULTIMA/USDT эсвэл TPTU/USDT). Дараа нь бот нь заасан стратегийн дагуу арилжааны үйл ажиллагааг автоматаар гүйцэтгэнэ.

Ultima Trading-ийн үндсэн давуу талууд:

- Тэргүүлэх крипто биржүүд дээрх арилжааны үйл явцуудын автоматжуулалт;
- Нэмэлт лиценз худалдаж авах замаар өргөтгөх боломжтой;
- Ultima-ийн экосистемийн бусад бүтээгдэхүүнтэй холбож болно;
- Ашиглаж болох арилжааны хэрэгслийн тоо байнга нэмэгдэж байдаг.

Ийнхүү Ultima Trading бол технологич байдал, хүртээмж болон өргөтгөх боломжийг өөртөө багтаасан Ultima-ийн экосистемийн тэргүүлэх бүтээгдэхүүн бөгөөд энэ нь түүнийг дэлхий даяарх хэрэглэгчдийн хувьд ач холбогдол бүхий хэрэгсэл болгодог.

### 7.1.3. SMART Wallet хэтэвч

[Кошелек SMART Wallet](#) хэтэвч бол Ultima токеныг дэмждэг олон үйлдэлт хэтэвч юм. Тус хэтэвч нь TRX, USDT, SMART ба ULTIMA зэрэг 20 гаруй коин болон токеныг дэмждэг. SMART Wallet-д шинэ хэтэвч нээснээр хэрэглэгч нь хувийн болон нийтийн түлхүүрийн цорын ганц эзэмшигч болох бөгөөд энэ нь таны хэтэвч дэх токен руу гуравдагч этгээд хандахыг боломжгүй болгох юм. Аппын функц мөн SMART Wallet-д одоо байгаа хэтэвчийг нэгтгэх боломжийг олгодог.

Түүнчлэн SMART Wallet нь ердөө цорын ганц мнемоник хэллэгээр 50 хүртэл крипто хэтэвчний хаяг үүсгэх боломжийг олгодог. Энэ нь SMART Wallet-тай ажиллах үеийн тав тухтай, аюулгүй байдал ба нэрийн нууцлалыг хангадаг.

#### 7.1.4. SMART Defender

[SMART Defender](#) гэдэг нь нууц түлхүүрийн тодорхой хэсгийг хадгалдаг NFC чиптэй биет карт юм. Түүнийг SMART Wallet-д криптовалют шилжүүлэх, сплитингийн урамшууллын хүсэлт гаргах зэрэг гүйлгээ баталгаажуулахад ашигладаг. Гүйлгээг баталгаажуулахын тулд зүгээр л SMART Defender хүйтэн хэтэвчийг SMART Wallet аппыг суулгасан гар утсандаа хүргэхэд болно.

SMART Defender нь таны хэтэвчийг биет түвшинд хамгаална, түүнд программын хувьд халдах боломжгүй. Энэ нь өөртөө хувийн түлхүүрийн тодорхой хэсгийг хадгалдаг. Хувийн түлхүүр гэдэг нь програмын кодонд бичигдсэн мнемоник хэллэг юм – өөрөөр хэлбэл хэтэвчний үүсгэгдэх үедээ бий болгодог үгсийн жагсаалт гэсэн үг. Үүний зэрэгцээ хувийн түлхүүрийг хувааж, шифрлэдэг. Хуваалт нь санамсаргүй дарааллаар явагддаг бөгөөд хувийн түлхүүрийн аль хэсэг нь SMART Defender дээр бичигдсэнийг хэн ч мэдэх боломжгүй байдаг. Энэ нь Defender-ийг хакердах боломжгүй болгодог.

SMART Defender-ийн бас нэг давуу тал нь ашиглахад хялбар байдал юм: түүнд зориулж ямар нэгэн нэмэлт программ хангамж татаж суулгах шаардлагагүй бөгөөд энэ нь хүйтэн хэтэвчний хувьд ховор байдаг давуу тал юм.

Түүнчлэн, SMART Defender-ийг хялбар тохируулах боломжтой, мөн түүнийг одоо байгаа хэтэвчиндээ холбож болно. Хүйтэн хэтэвчтэй ажиллаж байсан туршлагатай хэрэглэгчдэд энэ давуу тал үнэхээр таалагдах болно.

#### 7.1.5. Ultima Card крипто дебит карт

Ultima экосистемийн бас нэг онцгой бүтээгдэхүүн бол Ultima Card юм. Тус бүтээгдэхүүн нь криптовалютыг ашиглахад хялбар болгох хэмээх төслийн үндсэн зорилгод бүрэн нийцдэг. Ultima Card нь крипто зах зээл болон фиатын хоорондох бат бөх гүүр болсон. Өнөөдрийн байдлаар тус крипто картаар Европоос Латин Америк хүртэл, Азиас Африк хүртэл дэлхийн 100 гаруй улс оронд худалдан авалтынхаа төлбөрийг хийх боломжтой. Картын тусламжтайгаар дэлхий даяар байрлах АТМ-с бэлэн мөнгө авч болно. Биет болон виртуал крипто картыг авах боломжтой.

Ultima Card нь BTC, USDT, USDC зэрэг алдартай криптовалютыг дэмждэг – тэднийг тусламжтайгаар криптовалютын хүссэн хэтэвчнээсээ картын дансыг цэнэглэх боломжтой. Түүнээс гадна, Ultima Card нь Apple Pay ба Google Pay-г дэмждэг.

Ultima Card нь хэрэглэгчдэдээ ашиглалтын ашигтай нөхцөлийг санал болгодог:

- Европын нутаг дэвсгэрт шимтгэлгүй бөгөөд түүнээс гаднах нутаг дэвсгэрт бага шимтгэлтэй;
- сард 100 000 мянган евро хүртэл ба өдөрт 10 000 евро хүртэл хязгаартай;
- үйлчилгээний хураамж бага;
- виртуал карт гаргах боломж;
- нэг үйлчлүүлэгчид 3 хүртэл карт бүртгүүлэх боломж;
- аюулгүй байдал: Ultima Card таны гүйлгээний агшин зуурын, аюулгүй боловсруулалтыг баталдаг. Тус карт нь чип ба ПИН кодтой бөгөөд энэ нь таны хөрөнгийг аюулгүй байдал болон хамгаалалтын нэмэлт түвшнээр хангадаг.

### 7.1.6. Battle Games

Ultima мөн тоглоомын салбарт онцгой анхаарал тавьж байна. Battle Games-ийн эрхэм зорилго нь эдгээр хоёр глобал салбарын уулзвар дээр бүтээгдэхүүн бий болгох замаар цахим спорт болон блокчейний зах зээлийг нэгтгэх явдал юм. 2024 онд Battle Bulls хэмээх анхны төслийг эхлүүлсэн. Ирээдүйд шинэ тоглоомууд гаргаж, Battle Games дээр суурилсан өөрсдийн тоглоомуудыг бий болгох хөгжүүлэгчдийг татахаар төлөвлөж байна.

#### 7.1.6.1. Battle Bulls тоглоом

Battle Bulls – энэ бол товшдог тоглоом ба тулааны олон хэрэглэгчтэй PvP тоглоомын элементийг хослуулсан Telegram-ийн онцгой үнэ төлбөргүй товшдог тоглоом юм.

Тус тоглоом нь хүн бүрд сонирхолтой байдаг: зугаа цэнгэл ба сонирхолтой тоглоомын үйл явц хайж байгаа хүмүүсээс эхлээд крипто төслөөс урт хугацааны ашиг хүртэх хүсэлтэй жинхэнэ крипто сонирхогчид хүртэл.

Зугаа цэнгэлд дуртай хүмүүст зориулж Battle Bulls товших үйлдлийг санал болгодог. Сэтгэл хөдөлгөм механик болон тогтмол шинэчлэлтүүдийн ачаар тус тоглоом нь өдөр тутмын тогтсон ажлаасаа амарч, тоглоомын үйл явцаас таашаал авахад тусалдаг. Тоглоомын үндсэн баатар болох бух дээр товшсоноор хэрэглэгч тоглоомын валют авдаг. Данс нэмэгдэхийн хэрээр зэрэглэл өсдөг бөгөөд энэ нь тоглоомын валютыг илүү хурдан хуримтлуулах боломжийг олгодог.

Battle Bulls бол зүгээр товшдог тоглоом биш. Хэрэглэгчдэд мөн дэлхийн өнцөг булан бүрийн тоглогчидтой сонирхолтой тулаанд оролцохыг санал болгодог. Ялалт бүр нь хэрэглэгчдийг тоглоомоос авах ашгийг нэмэгдүүлдэг картыг авах боломжийг нээдэг шинэ түвшинд гаргадаг.



Тоглоомын үндсэн давуу тал нь тоглоомын валютыг бодит токен болгож хөрвүүлэх боломж байдаг. Battle Bulls нь блокчейн ба криптовалюттай аль хэдийн холбогдож ажиллаж байгаагаараа гар утасны бусад тоглоомуудаас ялгардаг. Battle Bulls бол блокчейнтэй холбогдох ажлыг бодитоор хэрэгжүүлсэн анхны тоглоомуудын нэг бөгөөд энэ нь тоглогчдод криптовалюттай шууд харилцан ажиллах боломжийг олгодог. Энэ бол зүгээр концепц эсвэл ирээдүйн төлөвлөгөө биш – блокчейнтэй холбоотой бүх механизм аль хэдийн ажиллаж байгаа бөгөөд тэднийг хэрэглэгчид ашиглах боломжтой. Тоглоомын валют авахаас эхлээд бодит токен болгож хөрвүүлэх хүртэл тоглоомын нийт эдийн засаг блокчейн дээр суурилсан бөгөөд энэ нь бүх үйл ажиллагааны ил тод, аюулгүй байдлыг баталгаажуулдаг.

Battle Bulls-ийн үндсэн элементүүдийн нэг нь BULL токен юм. Тоглогчид “Нэг цагийн орлого” хуримтлуулсан дансны үлдэгдлээ BULL токен болгож хөрвүүлэх боломжтой. BULL токеныг авсны дараа тоглогчид түүний тусламжтайгаар тусгай тоглоомын санд урамшуулал үүсгэх эсвэл түүнийг бирж дээр арилжаалах боломжтой.

Сплитингийн тусламжтайгаар санд криптовалютаар урамшуулал хүртэж эхлэхийн тулд хэд хэдэн үйлдлийг гүйцэтгэх хэрэгтэй:

- “Нэг цагийн орлого” дансны тоглоомын еврог аирдропын тусламжтайгаар BULL токен болгож солих.
- Хүлээн авсан токеноо Ultima Wallet хэтэвчинд царцаах.
- 24 цагийн дараа анхны урамшууллаа авах хүсэлтийг гаргаж болно.

Урамшууллыг ULTIMA токеноор төлдөг. Хүлээн авсан ULTIMA-г шууд хөрөнгө болгож болно: бирж дээр эсвэл дотоод солилцогч дотор худалдах, экосистемийн бүтээгдэхүүнд ашиглах эсвэл ULTIMA санд царцаах боломжтой.

Дотоод валют нь платформын дотор үлддэг бусад тоглоомоос ялгаатай нь BULL-ийг платформоос гадна бодитоор ашиглах боломжтой бөгөөд энэ нь зах зээлийн бусад тоглогчдын дунд түүний чухал давуу тал болдог.

Блокчейнтэй холбогдсоны ачаар хэрэглэгчид тоглоомын ололт амжилтаа бодит дижитал хөрөнгө болгож хөрвүүлэх боломжтой байдаг нь тоглох урам зориг ба сонирхлыг нэмэгдүүлдэг. Ийм холболтын ачаар Battle Bulls нь хэрэглэгчдэд ашиг олох шинэ боломжуудыг санал болгосноор тоглоом ба крипто эдийн засгийн огтлолцол дээр онцгой байр суурийг эзэлдэг.

### 7.1.7. Ultima Store маркетплейс

[Ultima Store](#) бол зөвхөн Ultima нийгэмлэгийн гишүүд хамгийн алдартай маркетплейсийн ваучерын эзэн болж, ваучераа дурын бараа үйлчилгээг худалдаж авахдаа ашиглах боломжтой худалдааны өвөрмөц талбар юм.



### 7.1.8. Umarkt маркетплейс

[Umarkt](#) 100 гаруй ангиллын 5 сая гаруй бүтээгдэхүүнийг санал болгодог. Umarkt-ийн барааны нэр төрөл тогтмол шинэчлэгддэг бөгөөд маркетплейсийн интерфэйсийг ашиглахад дээд хэмжээний тав тухтай байдаг.

Төлбөрийг USDT (TRC-20) болон бусад үндсэн криптовалютаар хийж болно. Каталог тогтмол шинэчлэгдэж, хэрэглэгчдэд дижитал хөрөнгийг бодит бараа бүтээгдэхүүн худалдаж авахад зарцуулах тухтай арга замыг олгодог.

## 7.2. Боловсруулж буй бүтээгдэхүүнүүд

Хөгжүүлэлтийн шатанд одоогоор дараах бүтээгдэхүүнүүд байна:

### 7.2.1. Charity Crowdfunding ба StartUp Crowdfunding

[Charity Crowdfunding](#) ба [StartUp Crowdfunding](#) бол хүмүүс болон гарааны бизнес санаагаа дэвшүүлэн сурталчилж санхүүжилт авдаг, харин хэрэглэгчид ирээдүйтэй санааг дэмжих боломжийг авдаг краудфандинг платформ юм. Эхний платформ нь хүмүүст, хоёр дахь нь гарааны бизнест туслах зорилготой болно.

Тус талбарууд нь win-win зарчмаар ажилладаг: төсөл санхүүжилт авч, санаагаа сурталчлах боломжийг, харин ивээн тэтгэгчид сонирхсон төслүүдээ дэмжих боломжийг авна.

### 7.2.2. Ultima Travel Club

Ultima Travel Club бол 90% хүртэл хэмнэлттэйгээр тийз, зочид буудал, круиз захиалах, автомашин түрээслэх ба бусад идэвхтэй амралтын төлбөрийг төлөх боломжийг олгодог travel-үйлчилгээний зах зээл дээрх цорын ганц төсөл юм. Платформын төлбөр тооцоог ULTIMA токеноор хийдэг.

Тус аяллын платформын санд 90% хүртэл хямдралтай 2,5 сая зочид буудал ба вилл, 25\$-оос эхлэх үнэтэй 950 круиз аяллын компани, автомашин түрээслэх томоохон агентлагууд, 150 гаруй улс дахь 300 мянга гаруй идэвхтэй амралт аяллын санал болон бусад олон зүйл бий.

### 7.2.3. Дотоод солилцогч

Экосистемийн дотор экосистемийн токеныг хурдан бөгөөд шууд солилцох боломжийг олгодог дотоод солилцогч ажилладаг. Энэ нь солилцоо хийх үеийн цаг хугацаа хэмнэж, зардлыг бууруулдаг.

#### 7.2.4. NFT маркетплейс

NFT хэлбэрээр дижитал хөрөнгө бий болгох, худалдан авах, худалдах платформ. Хэрэглэгчид онцгой токен худалдах, дуудлага худалдаанд оролцох, давтагдашгүй цуглуулгуудыг нийтлэх ба худалдан авах боломжтой болно.

#### 7.2.5. Мемкоины платформ

Мем болон поп соёлоос сэдэвлэсэн токен гаргах ба солилцох хэрэгсэл. Тус платформ нь бүтээлч крипто төслүүдийг дэмжих, нийгэмлэгүүдийг харилцан ажиллагааны онцгой хэлбэрүүдэд татан оролцуулах зорилготой.

## 8. Road map

### 2023 он

#### Q1 2023:

- SMART Blockchain-ийн нээлт
- SMART Wallet-ийн APK хувилбар
- ULTIMA-ийн бирж дээрх арилжаа
- SMART-ийн бирж дээрх арилжаа

#### Q2-Q3 2023:

- DEFI-U-ийн нээлт
- Сурталчилгааны ажлын эхлэл
- Сплит лицензүүд
- SMART Wallet дахь шимтгэлүүд
- SMART Wallet App Store ба Google Play-д
- SMART-ийн MEXC дэх листинг

#### Q4 2023:

- ULTIMA-ийн CoinW дэх листинг
- ULTIMA-ийн Gate.io дэх листинг
- Хөрвөх чадварын шинэ сангуудын нээлт

# 2024 он

## Q1 2024:

- ULTIMA-ийн анхны халвинг
- ULTIMA ба SMART-ийн CoinMarketCap (CMC) дэх листинг
- ULTIMA-ийн Certik-аар дамжсан аудит
- ULTIMA-ийн код GitHub-ийн санд
- Ultima Card биет карт
- Ultima Cashback ба Ultima Store-оор дамжсан буцаан олголт
- ULTIMA-ийн Coinstore дэх листинг

## Q2 2024:

- Дубайд томоохон арга хэмжээ зохион байгуулах
- Сплит токены нээлт
- Сплитийн урамшуулал
- Урамшуулал төлөлт
- Freezing Fee ба Burn Fee шимтгэл нэвтрүүлэлт
- SMART Wallet-д 15 гаруй токен нэмэх
- SMART Defender-ийн танилцуулга
- Дотоод солилцогч
- SMART Wallet-ийг SMART Defender-тай холбох ажил
- Виртуал Ultima Card
- Umarkt маркетплейсийн нээлт
- SMART Wallet дахь SMART-ийн стейкинг

## Q3 2024:

- Сплитинг 1.0 технологийн хэрэгжүүлэлт
- Хөрвөх чадварын шинэ сангуудын нээлт
- ULTIMA-ийн шинэ крипто биржүүд дэх листинг
- Battle Bulls тоглоомын нээлт
- BULL-ийн аирдроп, сплитинг ба листинг
- SMART Wallet дахь шинэ дижитал хөрөнгө
- Сплитинг 3.0 (царцаалт) нэвтрүүлэх ажил

## Q4 2024:

- Хөрвөх чадварын шинэ сангуудын нээлт
- Фризинг лиценз ба ULTIMA gift токентой багцууд
- ULTIMA gift токен дээр суурилсан төлбөрийн систем
- SMART Wallet-ийн суурин дэлгэцийн хувилбар
- SMART Blockchain дэх санал хураалт ба урамшуулал
- Туслах ботын нээлт
- Сплитүүдийн листинг
- Солилцогчийн шинэ данснууд нэвтрүүлэх ажил
- ULTIMA-ийн BingX болон Coinstore дэх листинг

## 2025 он

### Q4 2025 – Q2 2026

- Tier-1 биржүүд дээрх листинг
- Шинэ крипто тоглоомуудын нээлт (Battle Bulls-ийн хөгжүүлэлт, крипто тоглоомын салбарын тэлэлт)
- ULTIMA токеныг холбож тоглоомын салбарыг өргөжүүлэх ажил
- UltimEX-ийн (DEX) нээлт

## 2026 год

### Q3–Q4 2026

- Ultima NFT платформын нээлт
- NFT маркетплейсийн нээлт
- SMART Wallet дэх шинэ токен болон зоосны дэмжлэг
- ULTIMA-г Ultima Card-тай холбох ажил
- SMART Wallet-ийн үйлдлийн цаашдын хөгжүүлэлт (шинэ блокчейн холболт, аюулгүй байдлын өргөжүүлсэн хэрэгслүүд)
- Нэмэлт GameFi бүтээгдэхүүн, тоглоомын студийн түншлэлийн нээлт
- ULTIMA-д зориулсан кроссчейн бриж хөгжүүлэлт

## 9. Зах зээлийн сорилтууд

Криптовалютын зах зээлд хөл тавьсныхаа дараа төслүүд нь олон асуудал бэрхшээлтэй тулгардаг: олон улс оронд хууль эрх зүйн зохицуулалт байхгүй, хакерын өндөр идэвхтэй байдал, олон нийтийн зүгээс криптовалютад үл итгэх байдал, хэт өндөр хэлбэлзэл.

Ultima баг энэ бүх асуудлыг амжилттай даван туулсаар ирсэн. Тухайлбал, дэлхийн өнцөг булан бүрээс цугларсан хуульчдын баг төслийн ажиллагаа явуулдаг улсуудын хууль тогтоомжийг сайтар нарийвчлан судалдаг. Болзошгүй халдлагад бүтээгдэхүүний тэсвэртэй байх чадварыг нэмэгдүүлэхээр хөгжүүлэгчдийн баг тогтмол ажилладаг бол Ultima баг хувийн мэдээлэл ба хэтэвчийг хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай хэрэглэгчдэд идэвхтэй мэдээлдэг. Баавгайн зах зээлийн үед ханшийг тогтвортой барихын тулд дефляцийн стратегийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ талаар бид тус баримт бичгийн 5-р заалтад дэлгэрэнгүй тайлбарласан. Үүнээс гадна Ultima-гийн маркетингийн баг сургалтын материал бэлтгэх, онлайн болон оффлайн арга хэмжээ зохион байгуулах зэрэг ажлыг хэрэгжүүлж криптовалютын тухай олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг.

## 10. Хариуцлагын тухай мэдэгдэл

Задлан шинжлэлийн энэхүү тайланд тайлбарласан мэдээлэл нь бүрэн гүйцэд биш байж болох бөгөөд гэрээний харилцааны ямар ч элементийг илтгэхгүй болно. Задлан шинжлэлийн энэхүү тайлангийн агуулга нь компанийн талуудын хувьд зайлшгүй биш бөгөөд задлан шинжлэлийн засаж залруулсан тайланг вебсайт дээрээ нийтлэх замаар компани нь токен худалдахаас өмнө, үеэр болон дараа хүссэн үедээ дурын шалтгаанаар задлан шинжлэлийн энэхүү тайлангийн хэсгийг өөрчлөх, засах, нэмэх эсвэл хасах эрхтэй.

Задлан шинжлэлийн энэхүү тайлан нь компанийн өмч бөгөөд дахин бичих, хуулах, гуравдагч этгээдэд дамжуулах эсвэл бусад хэлбэрээр тараахыг хориглоно. Задлан шинжлэлийн энэхүү тайлан нь зөвхөн хөндсөн нарийн асуудлуудтай холбоотой тодорхой үзэл баримтлалд зориулсан хөтөч маягаар ерөнхий мэдээлэл өгөхөд зориулагдсан болно.

Задлан шинжлэлийн энэхүү тайлан нь хөрөнгө оруулалт, хууль эрх зүй, татвар, норматив, санхүү, нягтлан бодох бүртгэлийн салбарын зөвлөгөө биш бөгөөд токен худалдан авах гүйлгээний ямар ч үнэлгээний цорын ганц үндэслэл байж болохгүй. Боломжит худалдан авагч нь токен худалдаж авахаасаа өмнө тийм гүйлгээний боломжит ашиг, үүрэг хариуцлага болон бусад үр дагаврыг тодорхойлохын тулд хууль эрх зүй, хөрөнгө оруулалт, татвар, нягтлан бодох бүртгэл болон бусад зөвлөхтэй зөвлөлдөх ёстой.

Задлан шинжлэлийн энэхүү тайлангийн ямар ч зүйлийг хөрөнгө оруулалт хийх нэг төрлийн зам эсвэл урилга гэж хүлээн авах ёсгүй, мөн аливаа хууль эрх зүйн хүрээнд ямар нэг үнэт цаас худалдан авах санал эсвэл түүнийг хийхэд өдөөхөд ямар ч байдлаар хамруулахгүй болно. Тус баримт бичиг нь дижитал токеноор эсвэл түүнийг ашиглан гүйлгээ хийхийг хориглосон эсвэл ямар нэг байдлаар хязгаарласан аливаа газрын хууль эрх зүйн харьяаллын хууль тогтоомж эсвэл норматив актын шаардлагыг тооцохгүйгээр үйлдэгдсэн бөгөөд түүнд захирагдахгүй.

Токен нь дижитал валют, үнэт цаас, бараа эсвэл санхүүгийн өөр ямар ч хэрэгсэл биш бөгөөд 1933 оны Үнэт цаасны тухай хууль, Америкийн Нэгдсэн Улсын аливаа муж улсын үнэт цаасны тухай хууль эсвэл токены боломжит эзэмшигч оршин суугч нь байж болох ямар ч харьяаллын үнэт цаасны тухай хууль зэрэг дурын өөр засгийн газрын үнэт цаасны тухай хуулийн дагуу бүртгэгдээгүй болно.

Токеныг байнгын оршин суух газар, байршил эсвэл бүртгэл нь (i) Америкийн Нэгдсэн Улс (муж улсууд болон Колумби тойргийн нутаг дэвсгэрийг оролцуулан), Пуэрто - Рико, Америкийн Нэгдсэн Улсын Виржиний арлууд, Америкийн Нэгдсэн Улсын эзэмшлийн бусад газар эсвэл (ii) холбогдох хууль эсвэл норматив актын дагуу дижитал токены гүйлгээг хориглосон эсвэл ямар нэг байдлаар хязгаарласан улс эсвэл нутаг дэвсгэр болох иргэн, хувь хүн, хуулийн этгээдэд санал болгохгүй эсвэл тараахгүй, мөн түүнчлэн эзэмшигчид нь үүнийг давтан худалдах эсвэл өөр хэлбэрээр өмчлөх эрхээ шилжүүлж болохгүй.

Токеныг эдгээр хязгаарлалтад хамрагдсан хүн токен худалдаж авсан бол түүнийг хууль бус, зөвшөөрөлгүй, залилан мэхлэх үндэслэлээр хийсэн бөгөөд үүний төлөө өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх болно.

Компани нь токен санал болгодоггүй, токен тараадаггүй, мөн Сингапур, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Өмнөд Солонгос эсвэл дижитал токентой холбогдуулан эсвэл түүнийг ашиглан гүйлгээ хийхэд хязгаарлалтын дүрэм үйлчилдэг эсвэл компаниас бүртгүүлэх эсвэл холбогдох төрийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг бусад улс, нутаг дэвсгэрт ямар нэг зохицуулалттай үйл ажиллагааны хүрээнд бизнес (үйл ажиллагаа) эрхэлдэггүй болно.

Токен худалдан авагч бүрд түүнийг харьяаллын улсынх нь хууль тогтоомжийн дагуу анхаарлыг нь хандуулахаар хууль ёсны дагуу бичиг баримтыг танилцуулж болох хүн мөн гэдэгт үндэслэн задлан шинжлэлийн энэхүү тайланг түүнд танилцуулсан болохыг сануулья.

Токены боломжит худалдан авагч бүр тухайн харьяаллын хүрээнд байхдаа токеныг хууль ёсоор худалдан авах, дараа нь улсынхаа харьяаллын хүрээнд оршин суух өөр худалдан авагчид дахин худалдах боломжтой эсэхээ тодорхойлох хариуцлага хүлээнэ.

Задлан шинжлэлийн энэхүү тайланд агуулагдах хэд хэдэн мэдэгдэл, үнэлгээ болон санхүүгийн мэдээлэл нь ирээдүйн хэтийн төлөвийн таамаглал эсвэл мэдээллийн шинжтэй болно. Хэтийн төлөвийн ийм мэдэгдэл эсвэл мэдээлэл нь бодит үйл явдал эсвэл үр дүн нь ирээдүйн хэтийн төлөвийн мэдэгдэл эсвэл мэдээлэлд илтгэсэн эсвэл илэрхийлсэн үнэлгээ эсвэл үр дүнгээс ихээхэн ялгаатай байхад хүргэж болзошгүй хэдийн мэдэгдсэн болон үл мэдэгдэх эрсдэл, тодорхойгүй байдалтай холбоотой болно.

Компани нь тус бичиг баримтад тайлбарласан болон холбогдох хууль тогтоомжийн дагуу токен худалдан авахад шаардагдах шалгуурыг хангаагүй хэн бүхэнд криптосистемд хандахаас татгалзах эрхтэй. Тэр дундаа компанийн тогтоосон зохих шалгуурыг хангаагүй этгээдэд өөрийн үзэмжийн дагуу хүссэн үедээ хандах эрх олгохоос татгалзаж болно.

Англи хэл дээрх задлан шинжлэлийн тайлан нь төслийн тухай мэдээллийн албан ёсны гол эх сурвалж болно. Энэхүү бичиг баримтад агуулагдсан мэдээллийг бусад хэл рүү үе үе орчуулж болно. Ийм орчуулгын явцад энэхүү бичиг баримтад агуулагдах зарим мэдээллийг алдсан эсвэл ташуудуулсан байж болзошгүй. Өөр ийм хувилбарын зурвасын үнэн зөв нарийвчлалд баталгаа өгөх боломжгүй. Ийм орчуулга болон англи хэл дээрх энэхүү бичиг баримтын хооронд ямар нэг зөрчил эсвэл зөрүү гарсан тохиолдолд англи хэл дээрх энэхүү бичиг баримтын заалт давуу эрхтэй болно.